

мэдээллийг цуглуулж, боловсруулж, дүн шинжилгээ хийх;

-Гадаад худалдаа эрхлэгч ААН, байгууллага, иргэдийн санхүүгийн болон гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтад өгөгдсөн мэдээллийн үнэн зөвийг нягтлан шалгах;

-Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, гарч байгаа зөрчлийг арилгуулах, хууль сахилтын түвшинг дээшлүүлэх чиглэлээр холбогдох зөвлөгөө, зөвлөмж өгөх;

-Татварын болон хууль хяналтын байгууллагатай хамтарсан шалгалт явуулах, үр дүнг тооцох, харилцан мэдээлэл солилцох.

ГААЛИЙН НӨХӨН БҮРДҮҮЛЭЛТИЙН ТАЛААР:

Гаалийн ерөнхий газрын даргын 2015 оны А/134 дугаар тушаалаар батлагдсан "Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам"-д заасны дагуу Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь өөрийн хууль сахилтын түвшинд хийсэн үнэлэлт, дүгнэлтийн үндсэн дээр гаалийн бүрдүүлэлттэй холбоотой алдааг залруулах зорилгоор гаалийн байгууллагад мэдүүлээгүй эсвэл дутуу мэдүүлсэн барааны гаалийн бүрдүүлэлт хийх хүсэлт гаргасныг үндэслэн Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар нь гаалийн 470 горимоор нөхөн бүрдүүлэлтийг хийдэг.

Бүрдүүлэлтийн дараах шалгалтын ач холбогдол нь:



Танд лавлах зүйл байна уу!



1800-1281

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулт



Санал

ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор "Гаалийн лавлах-1281" нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Хаяг:
Сүхбаатар дүүрэг, "Их тойруу-81/1",
Улаанбаатар-14193, Монгол Улс
Утас: (976-11) - 350049
Факс: (976-11) - 350048
E-mail: info@customs.mn
Интернет: <http://www.customs.gov.mn>



МОНГОЛ УЛСЫН
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТ



УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТ



ЭРХ ЗҮЙН ҮНДЭС:

ОУ-ЫН ХЭМЖЭЭНД:

1. ДГБ-ЫН ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ГОРИМЫГ ХЯЛБАРЧЛАХ, УЯЛДУУЛАХ ТУХАЙ ШИНЭЧЛЭН НАЙРУУЛСАН КИОТО КОНВЕНЦ: 6 дугаар бүлэг;

2. ДХБ-ЫН ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ ХЭЛЭЛЦЭЭР: Зүйл 7.5.1 - 7.5.4;

3. ДГБ-ЫН БАЙГУУЛЛАГЫН ЗӨВЛӨМЖҮҮД;

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД:

1. ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ;

2. ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ;

3. ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ ;

4. ГЕГ-ЫН ДАРГЫН 2015 ОНЫ А/134, ТООТ ТУШААЛААР БАТЛАГДСАН "БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ";

5. БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ.

БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТ НЬ:

Бүрдүүлэлтийн дараах шалгалт гэдэг нь гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн хяналтаас гаргах зөвшөөрөл олгосны дараа гадаад худалдаанд оролцогчдын худалдааны мэдээлэл, санхүү, нягтлан бодох бүртгэлийн болон анхан шатны бичиг баримт, цахим сангийн мэдээллийг нягтлан шалгах замаар гаалийн мэдүүлгийн үнэн зөвийг тодорхойлох, хууль сахилтын түвшинг үнэлэх шалгалт юм.



Бүрдүүлэлтийн дараах шалгалтын төрөл:



БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО:

- Гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- Гадаад худалдааг хөнгөвчлөх;
- Худалдааны луйвартай тэмцэх;
- Гадаад худалдаанд оролцогчдын хууль сахилтын түвшинд үнэлэлт өгөхөд оршино.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Гадаад худалдаанд оролцогч хуулийн этгээд болон гаалийн нэгжүүдийн хууль сахилтын түвшинг үнэлэх, сайжруулах;
- Улсын төсвийн орлогыг үнэн зөв бүрдүүлэх;
- Гаалийн нөхөн бүрдүүлэлтийг хийх 470 горим.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

- Гадаад худалдаанд оролцогч ААН, байгууллага, иргэдийн талаарх мэдээ

